



Унших чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн оюутны үйлчилгээг сайжруулснаар суралцах сонирхлыг идэвхижүүлэх нь.

Ли Янжиан 

Монгол Улсын Боловсролын Их Сургууль

Яйшийн Шийлэгмаа 

Монгол Улсын Боловсролын Их Сургууль

Алимаагийн Туяа 

Монгол Улсын Боловсролын Их Сургууль

<https://journal.mnier.mn>

Санал болгож буй эшлэл:

Ли, Я., Шийлэгмаа, Я., Туяа, А. (2025). Унших чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн оюутны үйлчилгээг сайжруулснаар суралцах сонирхлыг идэвхижүүлэх нь. *Боловсролын судалгааны Монголын сэтгүүл*, 30(1). <https://doi.org/10.56380/mjer.v30.1.1>

Stimulate interest in learning by improving student services aimed at developing reading skills

Li Yanjiang 

Mongolian State University of Education

Shilegmaa Yaish 

Mongolian State University of Education

Tuya Alimaa 

Mongolian State University of Education

To cite this article:

Yanjiang, L., Yaish, Sh., Alimaa, T. (2025). Stimulate interest in learning by improving student services aimed at developing reading skills. *Mongolian Journal of Educational Research*, 30(1). <https://doi.org/10.56380/mjer.v30.1.1>

The International Journal of Studies in Education and Science (IJSES) is a peer-reviewed scholarly online journal. This article may be used for research, teaching, and private study purposes. Authors alone are responsible for the contents of their articles. The journal owns the copyright of the articles. The publisher shall not be liable for any loss, actions, claims, proceedings, demand, or costs or damages whatsoever or howsoever caused arising directly or indirectly in connection with or arising out of the use of the research material. All authors are requested to disclose any actual or potential conflict of interest including any financial, personal or other relationships with other people or organizations regarding the submitted work.



This is an open access article under the Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0 International License.



Унших чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн оюутны үйлчилгээг сайжруулснаар суралцах сонирхлыг идэвхижүүлэх нь

(БНХАУ-ын ӨМӨЗО-нд суралцаж буй гадаад оюутнуудын жишээ нь дээр)

Ли Янжиан, Яйшийн Шийлэгмаа, Алимаагийн Туяа

Өгүүллийн мэдээлэл

ХУРААНГУЙ

Түүх:

Хүлээн авсан: 2024.12.16

Засаж сайжруулсан: 2025.02.03

Хэвлэхийг зөвшөөрсөн: 2025.02.19

Тулхуур үг:

Уншиж ойлгох чадвар
Оюутанд чиглэсэн академик
үйлчилгээ
Идэвхижүүлэлт
Байгууллагын чиг үүрэг

Өвөр монголын өөртөө засах оронд суралцаж буй гадаад оюутны хувьд бакалаврын сургалтад суралцахад нөлөөлж буй гол хүчин зүйлсийн нэг бол гадаад хэлээр уншиж ойлгох чадвар юм. Гадаад оронд дээд боловсрол эзэмшиж буй оюутнуудын тухайн улсын хэл соёлд суралцах үйл ажиллагааг зөвхөн хятад хэлний хичээлээр хязгаарлахгүйгээр өөр олон боломж байгаагийн нэг нь оюутанд зориулсан академик үйлчилгээ юм. Бид энэхүү судалгааны ажилдаа оюутнуудын гадаад хэлээр уншиж сурахад нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлэн, унших чадварыг сайжруулснаар тухайн улсын хэл соёлд суралцах, бакалаврын боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэхэд гадаад оюутан хариуцсан албаны чиг үүргийн хүрээнд тэдэнд чиглэсэн академик үйлчилгээг амжилттай зохион байгуулснаар оюутны суралцах сонирхлыг идэвхижүүлэх боломж байгаа талаар дурдсан болно. Мөн ӨМӨЗО-нд суралцаж буй гадаад оюутнуудын уншиж ойлгох чадварыг асуулгын аргаар судлан тодорхойлж, энэхүү чадварыг нь хөгжүүлэхэд тэдэнд тулгамдаж буй асуудал болон гадаад оюутан хариуцсан алба болон багш, оюутнуудын хамтын ажиллагаагаар тэдний хөгжлийг дэмжих ямар боломж байгааг судалгааны үр дүнгээс харж болно.



Энэхүү өгүүлэл нь Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0 Олон улсын лицензээр хамгаалагдсан болно

Холбоо барих зохиогч:

Алимаа Туяа

Монгол Улсын Боловсролын Их Сургууль

Email: tuya.a@msue.edu.mn

Stimulate interest in learning by improving student services aimed at developing reading skills

Li Yanjiang, Shiilegmaa Yaish, Tuya Alimaa

Article information

ABSTRACT

Article history:

Received: Dec 16, 2024

Revised: Feb 03, 2025

Accepted: Feb 19, 2025

Keywords:

Reading ability
Student supported academic services
Motivation
Organizational functions

For a foreign student studying in the Inner Mongolia Autonomous Region, one of the main factors affecting the undergraduate course is the ability to read and understand a foreign language. Academic services for students are one of the many opportunities for students pursuing higher education abroad, not limited to Chinese language courses.

In this article, we have mentioned how the organization responsible for foreign students can activate students' interest in learning by successfully organizing student-oriented academic services within the scope of their functions.

Also, the reading and comprehension skills of foreign students studying in UMZU will be determined through questionnaires, and the organizations responsible for foreign students, teachers and students will work together to find out what problems students face in developing this ability. It can be seen from the results of the research that there is a possibility to develop skills.



This is an open access article under the Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0 International License.

Corresponding author:

Tuya Alimaa

Mongolian National University of Education

Email: tuya.a@msue.edu.mn

УДИРТГАЛ

Их, дээд сургуулийн хувьд олон улсын оюутнуудыг өөрийн улсад бакалаврын түвшинд амжилттай суралцуулах нь гол чиг үүргийн нэг бөгөөд энэ нь тухайн сургуулийн хөгжлийн ахиц дэвшлийг харуулах томоохон шалгуур үзүүлэлтийн нэг болдог. Энэхүү ажлыг зохион байгуулах нэгж нь гадаад оюутанд дэмжлэг үзүүлэх бүхий л үйл ажиллагааг хариуцан зохион байгуулдаг бөгөөд хамгийн хүндрэлтэй хэсэг нь хэл соёлын дасан зохицохуй байдаг. Энэ асуудлаас болоод оюутнууд сургуулиа орхих, амжилтгүй сурах явдал түгээмэл ажиглагддаг. Түүнчлэн гадаад оюутнуудын уншиж ойлгох чадвар хангалтгүй байгаа нь мэргэжлийн хичээлээ үзэхэд бэрхшээл үүсгэж, улмаар хувь хүний ирээдүй, чадварлаг мэргэжилтэн болж бэлтгэгдэн гарахад сөргөөр нөлөөлдөг талаар судлаачид бүтээлдээ дурдсаар байна. БНХАУ-ын ӨМӨЗО-нд суралцаж буй гадаад оюутнуудын унших чадварыг хөгжүүлэхэд зөвхөн хятад хэлний хичээлээр хязгаарлах нь хангалтгүй юм. Хичээл, сургалтын үйл ажиллагаанд зарцуулж буй цагаас бусад цагт тэдний унших чадварыг хөгжүүлэх ажлыг зохион байгуулснаар цаашид суралцах хүсэл сонирхол нь идэвхжих хандлага бий эсэхийг судлах хэрэгтэй байна. Үүний тулд их, дээд сургуулийн гадаад оюутанд чиглэсэн үйлчилгээний талаар судлах хэрэгцээ шаардлага байна.

Их, дээд сургуулийн оюутанд чиглэсэн үйлчилгээ (Student Support Service) нь барууны улс орнуудад академик болон хувь хүний, мэргэжлийн хөгжлийг дэмжихэд зориулагдсан тогтолцоо, бүтэц бүхий үйлчилгээний чиглэл болж хөгжсөн байна. Эдгээр үйлчилгээ нь академик, нийгмийн, сэтгэлзүйн болон мэргэжлийн дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн оюутны оролцоо, мотиваци, үйлдэл болон ерөнхий амжилтыг сайжруулахад чиглэгддэг бөгөөд шаардлагатай ур чадвараа хөгжүүлэх боломжуудыг оюутнуудад санал болгодог (Rain, 1985, p. 68). Оюутанд чиглэсэн үйлчилгээнд ихэвчлэн судалгааны ажлын зөвлөгөө өгөх, хэлний дэмжлэг үзүүлэх, хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар хөгжүүлэх зэрэг багтдаг бөгөөд төрөл бүрийн хөтөлбөр нь оюутны ур чадварыг нэмэгдүүлэх, сургалтын таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байдаг. Түүнчлэн их, дээд сургуулиуд өөрсдийн нэр хүндийг нэмэгдүүлэх, алсын хараанд хүрэхийн тулд оюутныг дэмжих үйлчилгээг хөгжүүлэх талаар стратеги төлөвлөгөөндөө тусган ажилладаг төдийгүй энэхүү үйлчилгээг хэрхэн өргөн хүрээнд, тэгш хүртээмжтэй хэрэгжүүлж чадна төдий чинээ олон элсэгчийг татах бодлого болдог тухай туршлага бий гэж судлаач Хэнк Хүйжсэр, Меган Чин А Кэк, Фернандо Пэдро нар “Их сургуулиудын оюутанд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ” бүтээлдээ дурдсан байна. (Henk Huijser, 2022)

БНХАУ-д суралцаж буй гадаад оюутнууд хэл, соёлын хувьд дасан зохицоход багагүй саад бэрхшээл, сорилтуудтай тулгардаг. Эдгээр сорилт нь тэдний цаашид амжилттай суралцахад хүндрэл учруулдаг. Их, дээд сургуулиуд соёлын чиг баримжаа олгох хөтөлбөр, нийгмийн дасан зохицол болон бусад олон зүйлийг дэмжих төрөл бүрийн зорилтот арга хэмжээг өөрийн онцлогт тохируулан зохион байгуулж байна.

БНХАУ-ын Боловсролын яамнаас 2017 онд батлан хэрэгжүүлж эхэлсэн 42 дугаартай тушаалд “Хятад улсад ирж буй оюутнуудын дээд боловсролын чанарын стандарт” баримт бичигт гадаадын оюутан нь соёлын олон янзын талаарх тодорхой ойлголттой, бусад улс орны соёл уламжлалыг танин мэдэх, дасан зохицох ухамсар, мэдлэг, хандлага болон ур чадвартай байхыг шаарддаг бөгөөд энэ нь үндэстэн, нийгэм болон улс хоорондын харилцан хүндэтгэл, ойлголцол болон эв нэгдэлд ихээхэн үүрэг гүйцэтгэдэг юм (БЯ, 2018). Бакалаврын боловсрол эзэмшихээр сурч буй суралцагчаас тухайн мэргэжлийн салбарт олон улсын хэмжээнд зохих алсын хараатай байж, тодорхой орчинд мэргэжлийн мэдлэг, ур чадвар эзэмшиж, олон улсын харилцаа, хамтын ажиллагаанд оролцох анхан шатны чадвартай байхыг шаарддаг.

Их, дээд сургуулиуд нь хятад улсад ирж байгаа гадаад оюутнуудын боловсролыг чанартай эзэмшүүлэхийн тулд дараах үйлчилгээг үзүүлэхийг уг баримт бичигт тусгасан байна. Их, дээд сургуулиуд гадаадын оюутанд дотуур байр буюу орон сууц, амьдрах байраар хангах, эмнэлгийн болон сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, бичиг баримтын бүрэн бүтэн байдал, мэдээллийн удирдлагаар хангах, хууль, дүрэм, аюулгүй ажиллагааны боловсрол олгох гэсэн 5 чиглэлээр үйлчилгээ үзүүлж байна. Харин бидний дээр дурдсан академик дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, нийгмийн болон сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ гэсэн 4

төрлөөс нийгмийн болон сэтгэл зүйн дэмжлэг дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд илүүтэй төвлөрч ажилладаг нь харагдаж байна. Иймээс хичээл, сургалтын үйл ажиллагаанд зарцуулж буй цагаас бусад цагт унших чадварыг хөгжүүлэх ажлыг гадаад оюутан хариуцсан албаны зүгээс менежментийн ямар бодлого үйл ажиллагааг оюутанд чиглэсэн академик дэмжлэг үзүүлэх үйлчилгээний хүрээнд хэрэгжүүлбэл ач холбогдолтойг судлах хэрэгцээ шаардлага тулгарсан болно. Энэхүү судалгааны ажлын хүрээнд бакалаврын боловсрол олгох сургалтын хөтөлбөрөөр хэрэгжүүлж буй хятад хэлний хичээлээс гадна унших чадварыг хөгжүүлэх оюутанд чиглэсэн академик үйлчилгээ нь тэдний сурах сонирхлыг идэвхжүүлэх боломж бий эсэхийг судлан тодорхойлох зорилго дэвшүүлсэн.

СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ

Сэдвийн судлах зүйлийг нарийвчлан авч үзэхийн тулд унших чадварыг хөгжүүлэх талаар онолын үндэслэл болон энэхүү чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн оюутны үйлчилгээний тухай онолын үзэл баримтлалын талаар судлаачдийн бүтээлийг авч үзсэн.

Уншиж ойлгох чадварын талаар судалсан эрдэмтдийн бүтээлийг тоймлон үзвэл судлаач Камми Макбрайд "Хятад хүүхдүүдийн уншлагын хөгжил" бүтээлдээ унших чадварыг хэрхэн эзэмшдэг танин мэдэхүйн болон соёлын талыг судлан бичсэн байна. Энэхүү бүтээлд уншиж ойлгох чадвар болон хоёр хэлээр бичиг үсэгт тайлах чадварыг сайжруулах стратегийг судалсан байна (McBride, 2019). БНХАУ-ын эрдэмтэн Дунпин Ян, Мин Ян, Шэнли Хуан нарын хамтран туурвисан "Боловсролын хөгжлийн талаар Хятадын судалгааны хэтийн төлөв, 6 дугаар боть" бүтээлд 2016-2018 оны боловсролын тэгш байдал, чанар, оюутны оролцооны талаарх судалгаануудад унших, ойлгох чадварын судалгааны үр дүнг танилцуулсан байдаг (Dongping Yang, 2022). Энэхүү бүтээлийн бидний судалгаатай холбогдож буй гол агуулга нь оюутнуудын сурлагын амжилтыг нэмэгдүүлэхийн тулд оюутанд чиглэсэн үйлчилгээг сайжруулахын чухлыг практик жишээгээр дурдсан байна. Бээжингийн их сургуулийн судлаач Мингюан Гу, Вэй Хэ Си нарын "Хятадын боловсролын цуврал судалгаа" бүтээлд Хятад улсын боловсролын практик орчин үеийн нөхцөлд хэр нийцтэй байгаа асуудал тухайлбал, уншлагыг хөгжүүлэх, оюутнуудыг дэмжих үр дүнтэй үйлчилгээг хэрхэн хослуулах боломж байгаа зэрэг судалгаанууд багтсан байна (Xie, 2022).

Юүхао Цэны “Хятадын дээд боловсролын оюутны суралцах ба хөгжил: Хятад дахь коллежийн оюутнуудын туршлага” бүтээлдээ их сургуулийн оюутныг дэмжих үйлчилгээний талаар дурдсан бөгөөд түүнд оюутныг дэмжих их сургуулийн хэрэгжүүлдэг төлөвлөгөө, цаашид хэрэгжүүлэх шинэлэг санааны талаар тусгаснаараа үнэ цэнтэй бүтээл болсон төдийгүй оюутны асуудал хариуцсан мэргэжилтнд чухал эх сурвалж болдог байна. Тэрээр бүтээлдээ их сургуулийн 64 оюутантай хийсэн ярилцлагын судалгаа болон БНХАУ-ын 21 их сургуулийн 23000 гаруй оюутнаас авсан асуулгын судалгааны мэдээлэлд үндэслэн тэдний сурах үйл явцад их сургуулиуд ямар дэмжлэг үзүүлж ажилладаг талаар судлаачийн байр сууринаас дүгнэн бичжээ (Cen, 2016, хууд. 116).

Дээрх бүтээлүүдэд их, дээд сургуульд суралцаж буй оюутны уншиж ойлгох чадварыг хөгжүүлснээр сурах сонирхлыг идэвхжүүлэх боломж байгааг судлан тодорхойлсон судалгаа багагүй байгаа хэдий ч гадаад оюутан хариуцсан албаны зүгээс тэдэнд чиглэсэн академик үйлчилгээг сайжруулснаар суралцах сонирхлыг идэвхжүүлсэн талаар харьцангуй цөөн байна.

АРГА ЗҮЙ

Бид судалгааны ажлын хүрээнд хятад хэлээр суралцахад нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлснээр их, дээд сургуулийн гадаад оюутан хариуцсан албаас тэдэнд чиглэсэн академик үйлчилгээний зорилгыг тодорхойлох, оюутнууд уншиж ойлгох чадварынхаа одоогийн байдалд өөрийн үнэлгээ хийх, энэхүү чадварыг хөгжүүлэхэд багш нарын оролцоо ямар байгаа, хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар дамжуулан уншиж ойлгох чадварыг хөгжүүлэх ямар боломжууд байгааг тодорхойлохын тулд судалгаандаа БНХАУ-ын ӨМӨЗО-ны их сургуулиудад суралцаж буй 174 оюутан, 30 багшийг хамруулсан.

Энэхүү судалгааг БНХАУ-ын ӨМБИС, ӨМИС, ӨМАҮИС-д суралцаж буй оюутнууд болон хятад хэлний бэлтгэл болон бакалаврын түвшинд хичээл зааж буй багш нараас асуулгын аргаар цахимаар судалгааг авч харьцуулсан дүгнэлтүүдийг хийлээ. Оюутнуудаас судалгаанд эс оролцох болон оролцохыг зөвшөөрөх мэдэгдлийг цахимаар урьдчилан асуусан болно. Судалгааны онолын материалд баримт бичгийн анализ болон унших үйлийн онол арга зүйн дагуу үр дүнг тооцох, сайжруулах гэсэн үйлийн судалгааны аргуудыг хэрэглэж, туршилт судалгааг Латейф Кар (Latief CAR, 2019)-ын мөчлөгт үйлийн аргаар тавьж үр дүнг нэгтгэсэн.

ҮР ДҮН

Судалгааны үр дүнг хоёр хэсэгт хуваан авч үзсэн бөгөөд эхлээд ӨМӨЗО-нд суралцаж буй гадаад оюутнуудын уншиж ойлгох чадвараа үнэлсэн өөрийн үнэлгээний үр дүн болон багш нараас авсан судалгаатай харьцуулсан дүгнэлт хийсэн. Харин хоёр дахь нь дээрх судалгаанд үндэслэн оюутанд дэмжлэг үзүүлэх академик үйлчилгээг хэрэгжүүлсэн туршилтын үр дүн юм.

Судалгааны ажлын эхний үр дүн:

ӨМӨЗО-нд суралцаж буй гадаад оюутнуудын унших чадвар болон энэхүү үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлж буйг судлах зорилгоор 174 оюутнаас асуулгын аргаар судалгаа авч, дүгнэсэн. Судалгаанд хамрагдсан нийт оюутны 30.5 хувь нь 18-19 хүртэлх насны, 29.3 хувь нь 20-21 насны, 18.4 хувь нь 22-23 насны, 21.8 хувь нь 24-өөс дээш насны ангилалд багтаж байсан бол 52.9 хувь нь эрэгтэй, 47.1 хувь нь эмэгтэй байв. Нийт оюутны 47.7 хувь нь хятад хэлээр унших чадвараа хангалттай сайн гэж үзсэн бол үлдсэн 52.3 хувь нь дунд болон түүнээс доош хэмээн үнэлсэн. Үүнээс харахад оюутнуудын унших чадвар төдийлөн сайн биш байна хэмээн үзэх боломжтой (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Оюутнуудын хятад хэлээр унших чадвараа үнэлсэн өөрийн үнэлгээ

Өөрийн үнэлгээ	Тоо	Хувь
Маш сайн	10	5.75%
Сайн	73	41.95%
Дунд зэрэг	59	33.91%
Бага зэрэг	32	18.39%
Нийт	174	

Унших чадвараа дээшлүүлэхийн тулд хийдэг үйлийн талаар судалгаанд оролцсон оюутнуудын 45.0 орчим хувь нь ном уншиж тэмдэглэл хөтлөх, шинэ үг цээжлэх, 30.0-35.0 орчим хувь нь цахим сурах бичиг ашиглах, ангийн найзаасаа дэмжлэг хүсэх, 23.0-24.0 хувь нь хятад хэлээр тоглоом тоглох, нэмэлт сургалтад хамрагдах гэж давхардсан тоогоор хариулсан байна. Оюутнууд хичээл, сургалтын бус цагаар унших чадвараа ахиулахад санаа тавьж ямар нэгэн арга хэмжээ авч байгаа нь харагдаж байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Оюутнууд унших чадвараа сайжруулахын тулд өөрийгөө идэвхжүүлдэг аргууд

Давтамж	Тоо	Хувь
Гол агуулгыг уншиж ойлгохын тулд тэмдэглэл хөтөлж орчуулдаг	80	45.98%
Шинэ үг цээжилж, үгийн сангаа нэмэгдүүлдэг	87	50%
Ангийн найзаасаа тусламж хүсдэг	59	33.91%

Цахим сурах бичиг ашиглан бие даан сурдаг	60	 34.48%
Унших чадвараа сайжруулах нэмэлт сургалтад хамрагддаг	42	 24.14%
Хятад хэл сурах тоглоом тоглодог (Fun Chinese", FluentU, LinguPenguin)	41	 23.56%
Бусад аппликейшн	10	 5.75%
Нийт	174	


Хятад хэлээр уншиж буй бичвэрийн төрлийг тодорхойлбол 27.0 хувь нь шинжлэх ухааны ном бүтээл, 14.0 хувь нь сурах бичиг, 16.0 хувь нь уран зохиолын ном, 16.0 хувь нь сонин нийтлэл 12.0 хувь нь цахим бүтээл уншдаг байна. Оюутнуудын 41.0 хувь нь шинжлэх ухааны буюу хичээлтэй холбоотой материал, 16.0 хувь нь уран зохиолын болон хэл, соёлын холбогдолтой чөлөөт материалыг уншдаг гэж хариулжээ (Зураг 2).

Зураг 2 . Хятад хэлээр уншиж буй бичвэрийн төрөл



Судалгаанд хамрагдсан оюутнуудын хичээлийн бус цагаар хятад хэлээр унших чадвараа сайжруулж буй хугацаа хангалтгүй байгаа бөгөөд өдөрт 2 цагаас илүү хугацааг зарцуулж буй оюутны хувь дөнгөж 9.8 байна (Зураг 3).

Зураг 3. Хичээлийн бус цагаар нэг өдөрт уншлаганд зарцуулж буй хугацаа



Багш нараас авсан судалгааны дүн: Багш нар гадаад оюутанд хичээлийн бус цагаар нэмэлтээр унших материалыг сонгохдоо тэдний сонирхлыг харгалзан өөр өөр материал өгдөг гэж 46.6 хувь нь хариулсан бол 30.0 хувь нь зөвхөн сурах бичгийн чанартай материалыг нэмэлтээр өгдөг гэж, 20.0 орчим хувь нь цахим эх сурвалжаас сонгодог гэж хариулсан байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Гадаад оюутны хятад хэлээр нэмэлт унших материал

Хариулт	Тоо	Хувь
Зөвхөн сурах бичиг	9	30%
Цахим эх сурвалж	6	20%
Сонирхлыг нь харгалзах	14	46.67%
Бусад	1	3.33%
Нийт	30	

Багш нар гадаад оюутнуудыг уншиж сургахад тулгарч буй бэрхшээлийг 76.6 хувь нь үгсийн сан муу, 56.6 хувь нь унших чадварт суралцаагүй, 53.3 хувь нь уншсан зүйлээ ойлгохгүй, 56.6 хувь нь сурах идэвх сул байгаагаас гэж дүгнэж байна (Хүснэгт 4).




Хүснэгт 4. Гадаад оюутнуудыг уншиж сургахад тулгарч буй бэрхшээл (давхардсан тоогоор)

Хариулт	Тоо	Хувь
Үгсийн сангийн мэдлэг муу	23	76.67%
Унших чадварт суралцаагүй	17	56.67%
Уншсан зүйлээ ойлгодоггүй	16	53.33%
Сурах идэвх сул	17	56.67%
Сууж сураагүй	7	23.33%
Бусад	0	0%
Нийт	30	

Гадаад оюутнуудыг уншиж сургахад шаардлагатай нэмэлт дэмжлэгүүдийн тухайд ихэнх хувь нь арга зүйг шинэчлэх, суралцагчдад сонирхолтой сургалтын аппликейшн ашиглах, хувь хүнийг идэвхжүүлэх арга хэмжээг зохион байгуулах гэж үзсэн байна (Хүснэгт 5)

Хүснэгт 5. Та гадаад оюутнуудыг уншиж сургахад шаардлагатай нэмэлт дэмжлэгүүд

Хариулт	Тоо	Хувь
Сургалтын арга зүйг шинэчлэх	18	60%
Сурах бичгийг шинэчлэх	12	40%
Тэдний сонирхолд нийцсэн сургалтын аппликейшн ашиглах	15	50%

Хамтран суралцах аргазүйг нэвтрүүлэх	13	 43.3%
Хувь хүнийг идэвхжүүлэх арга хэмжээг зохион байгуулах	22	 73.3%
Бусад	0	 0%

Багшаас болон оюутнуудаас авсан судлагааны үр дүнгээс хувь хүнийг идэвхжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хамтран суралцах арга замыг багшийн арга зүйд голчлон хэрэглэх шаардлага ӨМӨЗО-ны их, дээд сургуулиудын хувьд тулгамдсан асуудлын нэг болж буйг харуулж байна. Багш нар гадаад оюутнуудыг унших чадварыг дээшлүүлэхэд тулгамдаж буй бэрхшээлийг үгсийн сангийн дутмаг байдал, унших чадварт суралцаагүй байдал, сурах идэвх сул гэж тодорхойлсон бол оюутнууд суралцах чадвараа дээшлүүлэхийн тулд уншсан зүйлийнхээ талаар тэмдэглэл хөтлөх, шинэ үг цээжлэх, үгсийн сангаа нэмэгдүүлэх хэрэгтэй хэмээн хариулжээ. Энэ нь багш, оюутны аль алины хувьд унших чадварыг дээшлүүлэх талаар тодорхой арга хэмжээ авах зайлшгүй шаардлага байгааг харуулж байна.

Багш нар гадаад оюутны унших чадварыг нэмэгдүүлэхэд шаардлагатай нэмэлт дэмжлэгүүдийн тухайд сургалтын арга зүйг шинэчлэх, сургалтын сонирхолтой аппликейшн ашиглах, хувь хүнийг идэвхжүүлэх арга хэмжээг зохион байгуулах гэж үзэж байгаа бол оюутнууд цахим бүтээгдэхүүн ашиглах, хятад хэл сурах тоглоом ашиглах ангийн найзтайгаа хамтран суралцах, багаар ажиллах нь илүү үр дүнтэй хэмээсэн нь тэдний хариултын агуулгын хувьд ойролцоо байна. Оюутны хичээлээс гадуур уншлагад зарцуулж буй хугацаа бага, унших материалын сонголт ихэвчлэн шинжлэх ухааны буюу хичээлтэй холбоотой материал байгаа нь тэдний суралцах сонирхлыг бууруулж, хичээлийн бус цагаар унших чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн хувь хүний идэвхжүүлэлтийн ажил төдийлөн явагддаггүй байна.

Судалгааны хоёр дахь үр дүн:

Хоёр дахь нь ӨМАҮИС-ийн Олон улсын боловсролын дээд сургуулийн гадаад оюутны сургалтын менежмент болон дотуур байрны үйл ажиллагааг хариуцсан албаны чиг үүргийн хүрээнд судалгааны ажлын эхний үр дүнд тулгуурлан унших үйл ажиллагаанд суурилсан оюутанд академик дэмжлэгийн үйлчилгээг үзүүлэх чиглэлээр зохион байгуулсан туршилт судалгааны үр дүн болно. Туршилт судалгаанд тус сургуулийн хэлний бэлтгэл болон 1 дүгээр ангид суралцаж буй 40 оюутныг хамруулсан болно.

Санал болгосон уншихуйн чадварыг нэмэгдүүлэх арга зүй: Туршилт судалгааг Латейф Кар (Latief CAR, 2019)-ын мөчлөгт үйлийн аргаар тавьсан бөгөөд энэхүү арга нь ажиглалт, төлөвлөлт, хэрэгжилт, эрэгцүүлэмж гэсэн 4 үйлээс бүрддэг. Бид судалгаанд ашиглахаар хятадын болон дэлхийн түүх, соёлтой холбоотой 30 бүтээлийн хятад хэлээр бичигдсэн хувилбарыг сонгон авч бэлтгэсэн бөгөөд тэдгээрээс ёс зүй, утга найруулга, эртний хятадын философи зэрэг олон талаас нь харж байж “Тариачин өвөө ба могой”, “Чоно ирлээ” гэсэн 2 өгүүллийг туршилтад хэрэглэсэн. Туршилтад 40 оюутныг 5 бүлэгт, бүлэг тус бүрд 8 байхаар хамруулж хичээлийн бус цагаар оюутанд үйлчилгээ үзүүлэх албаны мэргэжилтнүүдтэй хамтран зохион байгуулсан. Төлөвлөлт, ажиглалт ба хэрэгжүүлэлт, эргэцүүлэмжийг уламжлалт аргаар болон CAR-ын үйлийн аргаар төлөвлөж 4 хичээлийг 7 хоногт 1 удаа 45-90 минутаар зохион байгуулсан болно.

Хүснэгт 6. Уламжлалт аргаар зохион байгуулсан болон CAR-ын аргаар зохион байгуулсан хичээлийн ажиглалтын үр дүн

4 үйл	Үйл ажиллагаа	
Төлөвлөлт	Уламжлалт аргаар зохион байгуулсан хичээл - Хичээлд оюутнуудыг уламжлалт хэлбэрээр суулгаж хичээлийн сэдвийг самбарт бичиж танилцуулах	CAR-ын аргаар зохион байгуулсан хичээл - Хичээлд оюутнуудыг 5 багт хувааж багаар суулгах - Хичээлийн сэдвийг самбарт бичиж танилцуулах

	<ul style="list-style-type: none"> - 5 минут уншуулах - Чиглүүлэгтэй унших - Ижил утгатай үгсийг ялгах - Эерэг болон эсрэг дүрүүдийг ярилцах - Далд утга санааг тайлбарлах - Тест авах 	<ul style="list-style-type: none"> - 5 минут уншуулах - Баг бүр өгүүлэлд гарч байгаа шинэ үгсийг жагсаах (Тааж уншсан эсэхийг ажиглах зорилготой) - Толь бичиг тарааж, багууд шинэ үгээ ойлгож авах - Багуудад ажлын хуудас тараах - Ажлын хуудасны дагуу хоорондоо ярилцах - Багууд ижил утгатай үгсийг ялгах - Багуудад толь бичиг өгч, ижил утгатай үгсийн тайлбарыг уншиж ойлгох ажлыг хамтран гүйцэтгэх - Зөв дуудлагыг шалгах уншлага зохион байгуулах - Агуулгыг ярилцах - Эерэг болон эсрэг дүрүүдийг ярилцах - Далд утга санааг тайлбарлах - Тест авах
Хэлбэр	Уламжлалт хэлбэр	Багаар ажиллах
Ажиглалт	<ul style="list-style-type: none"> - Дүрмийн алдаанд анхаарч байсан - Үгсийн сангийн мэдлэг мууд санаа зовнисон. - Эргэлзээтэй үгийг тайлбарлахаас зайлсхийж байв. - Сурах эрмэлзлэл байгаа ч өөртөө итгэх итгэл бага байсан. - Зөв дуудаж чадахгүй байх вий гэхдээ сандарч буруу дуудаж байв. - Чиглүүлэгтэй уншлага хийх явцад дүрмийн болон дуудлагыг алдаа хийх айдас байхгүй болсон. Багшийн арга зүй чухал нь эндээс харагдаж байна. - Яваандаа оюутнуудын өөртөө итгэх итгэл нэмэгдсэн. - Нийт 2 удаагийн туршилт хичээлээр оюутнуудын дундаж оноо байсан 67.5 байсан. 	<ul style="list-style-type: none"> - Багаар ажилласнаар зохиолоос ойлгосон байдлыг илэрхийлэх оюутны тоо нэмэгдсэн. - Дүрмийн болон дуудлагын алдаа гаргасан хэдий ч уншсанаа зөв ойлгож зөв тайлбарлаж зөв хариулж байв. - Баг дээрээ ярилцах боломж олгосноор сурагчдын өөртөө итгэх итгэл болон уншиж ойлгох чадвар нэмэгдсэн. - Багуудын тестийн хариултууд ихэнх нь зөв байв. - Дүрүүдийн дүрслэл болон зохиол дахь дүрүүдийн сэтгэл хөдлөлийн байдлыг нарийн ойлгож тайлбарлаж чадсан нь өмнөх хичээлд ажиглагдаагүй давуу байдал болсон. - Нийт 2 удаагийн хичээлээр оюутнуудын дундаж оноо 88.7 байсан
Эргэцүүлэл	<ul style="list-style-type: none"> - Хичээлийн үйл ажиллагаанд бүх оюутнууд оролцоогүй. - Оюутнуудад өөртөө итгэх итгэл дутмаг байв. - Шинэ үгээ ойлгоогүй учраас урам зориггүй болох хандлага харагдаж байсан. - Зохиолын санааг илэрхийлэхдээ үгийн сан дутмаг байв. - Оюутнууд дэвтэр дээрээ тэмдэглэл бичсэн. - Цөөн оюутнууд хичээлд идэвхтэй оролцож хэлэлцүүлэгт хариулж байв. Цаашид бүх оюутныг жигд хамруулах асуудалд анхаарч ажиллах шаардлагатай. 	<ul style="list-style-type: none"> - Оюутан хэлэлцүүлэгт хамрагдах эрмэлзлэл нэмэгдсэн. - Өөрийн үзэл бодлоор таамаглах асуултуудад идэвхтэй хариулдаг болсон - Оюутнуудын итгэл нэмэгдсэн. - Багийн гишүүдийн үгийн сангийн мэдлэг, дуудлага сайжирсан нь хичээлд оролцох оролцоог нэмэгдүүлсэн.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Дээр өгүүлсэн судлагдсан байдалд дурдсан бүтээлүүдээс уншиж ойлгох чадварыг хөгжүүлснээр суралцагчийн сурах сонирхол дээшилдэг тухай болон их, дээд сургуулийн оюутанд чиглэсэн үйлчилгээний талаар хангалттай судалгаа байгааг та бүхэн харсан. Харин бидний энд танилцуулж буй судалгаа бол уншиж ойлгох чадварыг хөгжүүлэх ажлыг академик сургалтаас гадна хичээлээс гадуурх үйл ажиллагаа буюу их, дээд сургуулийн гадаад оюутанд үйлчилгээ үзүүлдэг албаас зохион байгуулсан үйл ажиллагааны үр дүнтэй холбосноороо онцлог болно.

ДҮГНЭЛТ

Судалгааны үр дүнд дараах дүгнэлтийг хийж байна.

- БНХАУ-ын ӨМӨЗО-нд суралцаж байгаа гадаад оюутанд чиглэсэн үйлчилгээ нь ихэвчлэн зохион байгуулалтын шинжтэй, өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах, соёлын болон нийгмийн дасан зохицохуйтай холбоотой үйл ажиллагаагаар хязгаарлагдаж байна. Өөрөөр хэлбэл оюутны академик үйлчилгээтэй холбоотой багаар ажиллахад чиглэсэн дасгал даалгаврыг бэлтгэх, хичээлийн төлөвлөлт, зорилго тодорхойлох уулзалт хийх, сургууль, номын сан болон суралцах төвүүдийг ажиллуулах, суралцах материалын судалгаа хийх, цагийн менежмент, шалгалтын бэлтгэл, хичээлд үр дүнтэй хандах аргаар сургалт явуулах гэх мэт үйлчилгээг одоогийн байдлаар зохицуулах үйлчилгээний стандарт, дүрэм журамд тусгагдаагүй байна.
- Унших чадварыг сайжруулах академик үйлчилгээг хятад хэлний хичээлээс ялгаатай байдлаар тодорхой арга зүйгээр зохион байгуулах туршилт судалгааг хийснээр хичээлд оролцох оюутны оролцоо 20.3 хувиар ахисан үр дүн үзүүлээ.
- Уншилтын үр дүнд баримжаалсан үйл явцын зураглал болон арга зүйн дагуу практик судалгааны туршилт хийх, их, дээд сургуульд суралцаж буй насанд хүрэгчдийн хувьд уншихуйг дэмжихийн тулд ямар үйл ажиллагааг зохион байгуулбал илүү үр дүнтэй, тулгарч буй бэрхшээлийг даван туулах, уншихад суралцаагүй уншихаас үүсдэг танин мэдэхүйн болон гоо сайханы таашаалыг хүртэж үзээгүй насанд хүрэгчдийг унших хүсэл сонирхолтой болгож унших чадварыг дээшлүүлснээр цаашид суралцах урам зоригийг бий болгоход сургууль, багш нар, хариуцсан алба нэгжүүдийн хамтын ажиллагаа болон нөлөөллийн үр дүнтэй зорилготой үйл ажиллагаа хэрэгтэй болохыг судлан тодорхойллоо. Цаашид ӨМӨЗО-ны их, дээд сургуулийн гадаад оюутанд чиглэсэн үйлчилгээг шинэ үйлчилгээгээр нэмэгдүүлж сургууль бүр өөрийн онцлогт тохирсон академик үйлчилгээг нэвтрүүлэхэд энэхүү судалгааны үр дүн, сургалтад хэрэглэсэн арга зүйг хэрэглэх боломж байгааг харуулж байна.

ЗОХИОГЧДЫН ОРОЛЦОО

Онолын үндэс, санаа: Л.Я, А.Т, **Арга зүй:** Я.Ш, А.Т, **Мэдээлэл цуглуулалт:** Л.Я, А.Т, Я.Ш, **Боловсруулалт:** А.Т, Л.Я, **Бичилтийн эхний хувилбар:** А.Т, Л.Я, **Хяналт:** А.Т, Я.Ш,Л.Я, **Мэргэжлийн удирдлага:** А.Т, Я.Ш

НОМ ЗҮЙ

Cen, Y. (2016). Student Learning and Development in Chinese Higher Education: College students' experience in China (Education and Society in China. 978-1138905481, 114.

Dongping Yang, M. Y. (2022). Chinese Research Perspectives on Educational Development, . Volume 6.

Henk Huijser, M. Y. (2022). Student Support Services,). Springer Nature Singapore Pte Ltd. 978-981-16-5850-1.75.

McBride, C. (2019). *Reading Development in Chinese Children*.

Otis-Lennon. (n.d.). OLSAT School Ability Test .

Rain, D. (1985). *Self-Determination Theory: Self-determination Theory and the Facilitation of Intrinsic Motivation, Social Development, and Well-being*.

Xie, M. G. (2022). *Research in Chinese Education Series*.

БЯ, Б.-ы. (2018). *Хятад дахь олон улсын оюутнуудын боловсролын чанарын стандарт*.

Ц, Б. (2011). *Англи хэлээр суралцагчдад уншиж ойлгох арга барил эзэмшүүлэх арга зүйн судалгаа*.
Улаанбаатар: БИТ.

Зохиогчдын мэдээлэл

Овог, нэр: Li Yanjiang

 <https://orcid.org/0009-0005-9612-4925>

Байгууллагын нэр: МУБИС, БОСС

Боловсролын удирдлагын тэнхмийн

докторант

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот - 14191,

СБД, 8-р хороо, Бага тойруу – 14

Улс: БНХАУ

e-mail: 2686841024@qq.com

Овог, нэр: Я.Шийлэгмаа

 <https://orcid.org/0009-0007-8572-7100>

Байгууллагын нэр: МУБИС, БОСС,

Боловсролын удирдлагын тэнхим

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот - 14191,

СБД, 8-р хороо, Бага тойруу – 14

Улс: Монгол

e-mail: shiilegmaa@msue.edu.mn

Овог, нэр: А.Туяа

 <https://orcid.org/0009-0007-1587-034X>

Байгууллагын нэр: МУБИС, БОСС,

Боловсролын удирдлагын тэнхим

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот - 14191,

СБД, 8-р хороо, Бага тойруу – 14

Улс: Монгол